



**ГАЛТ ТЭРЭГНИЙ
ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН
НЭГДСЭН ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2021 оны 03 сарын 16 өдөр

Дугаар A/23

Улаанбаатар хот

Гэрчилгээжүүлэх ажлын хэсгийн ажиллах
заавар батлах тухай

Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журмын 3.1.10, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны “Эрх шилжүүлэх тухай” А/13 дугаар тушаал, Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар хооронд байгуулсан “Төрийн зарим ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх тухай” 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 47 дугаартай гэрээ, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын дүрмийн 4.2, 6.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/13 дугаар тушаалаар төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр “ГТХЗНТ” УТҮГ-т шилжүүлсэнтэй холбогдуулан Гэрчилгээжүүлэх ажлын хэсгийн ажиллах зааврыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Гэрчилгээжүүлэх ажлын хэсгийн ажиллах зааврыг хэрэгжүүлж ажиллахыг Ажлын хэсэгт, зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсэг /Ц.Оюунбат/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн “Заавар батлах тухай” А/30 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



А.БУЯННЭМЭХ

000800